



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/530

Мандлговь

Газар эзэмших эрх  
дуусгавар болгох тухай

Монгол улсын Газрын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3, 39.1.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын төвийн 7 дугаар багийн нутаг дэвсгэрт (Мандалын баруун талд, ногооны талбайн хашаанд КТП-20) байршилтай БЗӨБ-ийн ЦТС ХК Дундговь салбар (РД:2008904)-ын 4 м<sup>2</sup> (0.004 га) газар нь бусдын эзэмшиж байгаа газартай давхцаж байгаа тул газар эзэмших эрхийг дуусгавар болгосугай.

Хоёр. Дээрх байгууллагын газар эзэмших гэрээг цуцалж, гэрчилгээг хүчингүй болгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2010 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 41 тоот захирамжийн 12 дах хэсэг мөн газар эзэмших 0209336 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

438010632